

“ЗАМЫН-ҮҮД” ЧӨЛӨӨТ БҮСИЙН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Замын-Үүд чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба нь “Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн 2016 онд Аж үйлдвэрийн сайдтай хийсэн үр дүнгийн гэрээ, гэрээний хавсралт болох үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ Чөлөөт бүсийн талаар төрөөс баримтлах бодлого, Засгийн газар, Төрийн захиргааны байгууллагын бодлого шийдвэрийг удирдлага болгон үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж ажиллалаа.

Засгийн газрын 2015 оны 126-р тогтоол, Аж үйлдвэрийн сайдын 93-р тушаалаар баталсан бүтцийн хүрээнд 5 хэлтэс, */Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтэс, Дэд бүтцийн хөгжил, газрын харилцааны хэлтэс, Гэрээ эрх зүй хүний нөөцийн хэлтэс, Гадаад харилцаа хамтын ажиллагаа, мэдээлэл технологийн хэлтэс, Бүртгэл санхүүгийн хэлтэс/* 29 ажилтан албан хаагчтай үйл ажиллгаагаа явуулж байна.

2016 оны 8 сард Засгийн газрын бүтэц шинэчлэн батлагдсантай холбогдуулан “Замын-Үүд” чөлөөт бүс нь Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжиж, төрийн албаны тасралтгүй үйл ажиллагааг хангаж, 2016-2020 оны Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгасан салбарын бодлогын хэрэгжилтийг удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллаж байна.

Төсвийн шууд захирагчийн гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу гэрээний хавсралт болох “Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн Ажлын Албаны 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тусгагдсан **29 нийт арга хэмжээ, төсвийн ерөнхийлөн захирагчийн тусгайлан сонгосон 5 арга хэмжээг** гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнаж байна.

1. “Чөлөөт бүсийн стратегийн зорилтыг хангах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хөгжүүлэх, бодлого боловсруулах, удирдамжаар хангах, хэрэгжилтийг зохицуулах” зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд:

1.1 “Аж үйлдвэрийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж, үйлдвэрийн кластер, чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн парк, тээвэр логистикийн сүлжээг цогцоор төлөвлөн хэрэгжүүлэх” чиглэлээр:

Биелэлт:

- Замын-Үүд чөлөөт бүс дэх газар олголтын ажлыг Засгийн газраас 2011 онд батлагдсан Замын-Үүд чөлөөт бүсийн мастер төлөвлөгөөний газар зохион байгуулалтын төлөвлөгөөг баримтлан зохион байгуулсан. 2016 онд газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалтын ажил явагдаагүй учир тээвэр логистикийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар эрх авсан аж ахуйн нэгжүүдийн төслийн биелэлтэнд хяналт тавьж, үйл ажиллагаа эхлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд заавар зөвлөгөөг өгч ажиллаж байна.
- Ерөнхий сайдын 2015 оны 11 сарын 5-ны 216 дугаар захирамж, АҮЯ-ны ТНБД-ын 2015 оны 11 сарын 24-ны 281 тушаалаар Монгол Улс БНХАУ-ын хооронд хил дамнасан чөлөөт бүс байгуулах асуудлыг судлах ажлын хэсэг, дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Замын-Үүд чөлөөт бүсийн ЗАА-ны албан тушаалтнууд орж ажиллан “Хил дамнасан чөлөөт бүс байгуулах Урьдчилсан ТЭЗҮ” боловсруулах ажлын даалгаврыг боловсруулсан. Уг даалгаварт ХДЧБ-ийн талбайг 2 хувилбараар

боловсруулах, тээвэр логистикийн сүлжээг цогцоор нь төлөвлөн хэрэгжүүлэх талаар тусгаж ажилласан.

- “Замын-Үүд” чөлөөт бүсэд тээвэр логистикийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар шалгарсан аж ахуйн нэгжүүдэд “Чөлөөт бүсийн тухай хууль”-ийн холбогдох заалтын дагуу зөвлөгөө, мэдээллээр ханган, хамтран ажиллаж байна.
- “Замын-Үүд” чөлөөт бүсийн нутаг дэвсгэрийн орчмоор дайран өнгөрөх АНЗ хурдны автозамын трассыг албан ёсоор баталгаажуулсан эсэхийг тодруулахаар Зам тээврийн яаманд 2016 оны 02 сарын 24 өдрийн 1/32 тоотыг хүргүүлж, АНЗ хурдны замын трасс нь албан ёсоор батлагдаагүй гэсэн хариуг тус яамнаас ирүүлсэн.

1.2 “Чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн парсад” үйлдвэрлэл эрхлэгчдэд татварын бодлогоор дэмжлэг үзүүлэх” арга хэмжээний хүрээнд:

Биелэлт:

- Татварын ерөнхий газартай байгуулсан 2015 оны 07 сарын 09-ны1/36 тоот хамтран ажиллах гэрээнд чөлөөт бүсэд бүртгэгдэх хуулийн этгээдийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн зохицуулалтыг улсын бүртгэлийн ерөнхий газартай хамтран бүртгэх талаарх заалтыг оруулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
- Байгууллагын цахим хуудас, орос, англи, хятад хэл дээрх блогт татварын хөнгөлөлт чөлөөлөлт, чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх давуу талыг сурталчлан ажиллаж байна.
- “Замын-Үүд” чөлөөт бүсэд үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар эрх авсан “Хэв хашмал чөлөөт бүс” ХХК-ийн үйлдвэрийн барилгын материал болон тоног төхөөрөмж, түүхий эдийн гааль татварын хөнгөлөлт чөлөөлөлтийг Чөлөөт бүсийн тухай хуулийн 16-р зүйлд заасны дагуу шийдвэрлэн ажилласан.
- “Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл”-ийн 2016 онд хийх авто зам, холбооны ажилд шаардагдах бараа материалын тоо хэмжээг гааль, татварын ерөнхий газарт хүргүүлэн ажилласан.

1.3 “Экспортод чиглэсэн өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг чөлөөт бүсэд хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх” арга хэмжээний хүрээнд:

Биелэлт:

- “Хэв хашмал чөлөөт бүс” ХХК нь үйлдвэрийн барилга байгууламжаа 2016 оны 4 сараас эхэлсэн ба барилгын ажил бүрэн дуусч, экспорт болон дотоодын зах зээлд нийлүүлэх барилгын “Тай”, Пин зэрэг бүтээгдэхүүнийг туршилтын журмаар үйлдвэрлэж байна. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүндээ чанарын шаардлага, стандарт хангасан тухай тохирлын гэрчилгээ авах талаар зөвлөмж өгч ажиллав.
- “Хэв хашмал чөлөөт бүс” ХХК-ийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд шаардагдах цахилгааны эх үүсвэрийг бүсийн мэргэжлийн албадын нэгдсэн байрны хажууд байрлах өндөр хүчдэлээс агаарын түр шугам татуулах, холбогдох техникийн нөхцөлийг гаргуулан, трассыг тогтоон хэрэгжилтэнд хяналт тавин ажилласан.

1.4 “Чөлөөт бүсэд дэд бүтцийг хөгжүүлэх, бүтээн байгуулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих, бүсэд газар эзэмшүүлж, ашиглуулахтай холбогдсон харилцааг зохион байгуулах” чиглэлээр:

Биелэлт:

- “Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн Ажлын Албанаас газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалтыг 3 удаа зохион байгуулсан.
 - Оролцсон аж ахуйн нэгж - 63
 - Шалгарсан аж ахуйн нэгж - 32
 - Төсөл нь цуцлагдсан аж ахуйн нэгж - 17
 - Газрын төлбөрөө төлсөн аж ахуйн нэгж - 15
 - Газрын болон бүртгэлийн гэрчилгээ аваагүй аж ахуйн нэгж - 1
 - Газрын гэрчилгээ авсан аж ахуйн нэгж - 14
 - Бүртгэлийн гэрчилгээ авсан аж ахуйн нэгж -14
 - ХОГ байгуулсан аж ахуйн нэгж -10 байна.
- Газрын харилцаа барилга хот байгуулалтын газраас хэрэгжүүлж буй аймаг, нийслэл, сумдыг газрын нэгдсэн мэдээллийн санд холбох “Ланд менежер” программын хүрээнд “Замын-Үүд” чөлөөт бүсийн газрын харилцааг уг программд хамруулах, чөлөөт бүсийн тоон мэдээллийн санг үүсгэх, солбицолын тогтолцоог өөрчлөх зэрэг ажил хийгдэж байна.
- Чөлөөт бүсийн 1, 2-р хэсэгт хийгдэх хөрөнгө оруулалтын ажлын хүрээнд гүнийн гарцанд барих мэргэжлийн албадын нэгдсэн байрыг концессийн гэрээгээр, чөлөөт бүсийн хэсэгчилсэн төлөвлөгөө боловсруулах ажлын санхүүжилтийг 2016 оны улсын төсвийн тодотгол, төсвийн хүрээний мэдэгдэлд тусгуулах саналыг Аж үйлдвэрийн яаманд хүргүүлсэн.
- Төсөл сонгон шалгаруулалтаар шалгарсан 32 аж ахуйн нэгжийн удирдлагуудад чөлөөт бүсэд хийгдэж буй дэд бүтцийн бүтээн байгуулалт, Аж үйлдвэрийн яам, Захирагчийн Ажлын албанаас гарсан тушаал шийдвэрийн талаар мэдээлэл хийж, санал солилцлоо.
- Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан “Газар эзэмших ашиглах эрхийн төсөл сонгон шалгаруулах зар, мэдээг өөрчлөн хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

1.5 “Чөлөөт бүсийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг хүлээн авч, ашиглалт хариуцан ажиллах” чиглэлээр:

Биелэлт

- “Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл” болон гүйцэтгэгч байгууллага “Чайна Камк Инженеринг” компанийн удирдлагуудтай хэрэгжүүлж буй ажлын хүрээнд 2015 онд ажилласан техникийн болон улсын комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлт, зөрчил дутагдлыг арилгуулах, төслийн ажлыг эрчимжүүлэх, Улсын комиссыг ажиллуулах талаар

хурал зохион байгуулж, шаардлага хүргүүлэн ажилласан. Одоогийн байдлаар “Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд хийгдэж буй ажил дараах гүйцэтгэлтэй байна.

- “Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл”-ийн Ус хангамж, ариутгах татуургын багц ажлын хүрээнд Ус хангамж, ариутгах татуургын ажлын гүйцэтгэл бүрэн хийгдсэн ба 2016 оны 06 дугаар сарын 08-ны өдөр Барилга хот байгуулалтын яамнаас Улсын комиссын бүрэлдэхүүн ажиллаж ус хангамж ариутгах татуургын багц ажлыг хүлээн авсан.
- “Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл”-ийн Цахилгаан хангамжийн багц ажил хийгдэж дууссан. Улсын комисс ажиллах шаардлагатай.
- “Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл”-ийн Авто зам, холбоо дохиоллын багц ажлын хүрээнд Авто замын ажлын гүйцэтгэл бүрэн дууссан ба улсын комисс ажиллах шаардлагатай.
- “Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл”-ийн Дулаан хангамжийн багц ажлын хүрээнд 2016 оны 06 сард “Замын-Үүд” чөлөөт бүсэд хийгдсэн дулааны өгөх буцах шугам хоолойд ус шахаж, туршилт тохируулгын ажил хийгдсэн. Улсын комисст хүлээлгэн өгөх шаардлагатай.
- Дулааны станц руу нүүрс тээвэрлэх 3км төмөр замын ажил бүрэн дуусч, Зам тээврийн яамны Улсын комисс 2016 оны 5 сарын 27-ны өдөр хүлээн авсан.
- “Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл”-ийн 4 багц ажлыг 2016 онд хүлээн авах улсын комисс ажиллахтай холбогдуулан “Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл”-ийг хэрэгжүүлэгч нэгжээс 4 багц ажлын батлагдсан ажлын зургийг хуулбарлан авч албан хэрэгцээнд ашиглаж байна.
- “Замын-Үүд” чөлөөт бүсийн Ажлын албаны бүтэц орон тоо шинээр батлагдсантай холбогдуулан Дэд бүтцийн хөгжил, газрын харилцааны хэлтэст архитектор, дулааны инженер, цахилгааны инженер, усан хангамжийн инженер, холбооны инженерүүдийг шинээр авч, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна.
- “Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл”-ийн бүтээн байгуулалтын ажил удаашралтай, гэрээгээр хүлээсэн үүрэг төдийлөн хангагдахгүй байгаа тул ажлыг эрчимжүүлэх тухай шаардлагыг China Camc Injeenering Co.,ltd, Төслийн нэгжид, хувийг Монгол Улсад суугаа БНХАУ-ын элчин сайдын яам, Барилга хот байгуулалтын яаманд тус тус хүргүүлэн ажилласан.

1.6 “Замын-Үүд” чөлөөт бүсийн дэд бүтцийн барилга байгууламж, цаашдын төлөвлөлт, тулгамдаж буй асуудлаар санал боловсруулж ажиллах” чиглэлээр:

Биелэлт:

- Чөлөөт бүсийн 5, 6 дугаар хэсгийн дэд бүтцийн ажлын хүрээнд дулаан, цахилгаан хангамжийн ажлын урьдчилсан төсөвт холбогдох саналуудыг Төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн өгч ажилласан.

- “Замын-Үүд” чөлөөт бүсийн 1, 2 дугаар хэсгүүдийн дэд бүтэц, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх зорилгоор тус хоёр хэсгийн 200 га газрыг гадаад дотоодын хөрөнгө оруулагчид, аж ахуйн нэгжүүд бүхлээр нь хөгжүүлэх талаар санал боловсруулж Аж үйлдвэрийн яаманд хүргүүлсэн.
- “Замын-Үүд” чөлөөт бүсийн мэргэжлийн албадын нэгдсэн байрны гадна байрлах 150 тонны 2 ширхэг хэмжилтийн пүүний орц гарцын төлөвлөлтийн зураг шаардлага хангахгүй тул шинээр зураг төслийг хийж гүйцэтгүүлэхээр ажиллаж байна.
- 2016 оны 01/02 тоотой барилга хот байгуулалтын сайдад: Чөлөөт бүсэд барилга байгууламж барих, түүнийг эхлүүлэх үргэлжлүүлэх ашиглалтанд оруулах, барилга байгууламжийн эх зураг, загвар батлах талаар холбогдох хууль дүрэм, журамд тодорхой болгох саналыг хүргүүлсэн. Тус яамнаас “Хот байгуулалтын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төсөл, үзэл баримтлалын төсөл боловсруулах ажлын хүрээнд саналыг судлан үзэж шийдвэрлэх тухай хариу ирүүлсэн.
- “Замын-Үүд” чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулах эрх авсан аж ахуйн нэгж байгууллага барилга байгууламж барих, архитектур төлөвлөлтийн даалгавар, /Эскиз/ эх зураг баталгаажуулахтай холбогдсон хууль эрх зүйн орчинг тодорхойлох, Төрийн чиг үүргийг хамтран хэрэгжүүлэх зорилгоор Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газартай хамтран ажиллах гэрээний төслийг боловсруулан 2016 оны 07 сарын 06-нд хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласан.
- Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулах эрх үүссэн аж ахуйн нэгж байгууллагын ирүүлсэн барилга байгууламжийн эх зураг /Эскиз/-ийг ЗАА-ны архитектор шалгаж, зөвлөмжөөр ханган ажиллаж байна.

1.7 “Замын-үүд” чөлөөт бүсийн мастер төлөвлөгөөнд үндэслэн чөлөөт бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах хөрөнгө оруулалтын ажлыг шийдвэрлэх” чиглэлээр:

Биелэлт:

- Чөлөөт бүсийн 2-р ээлжийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг Энэтхэг, БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн санал, Монгол Улсын 2016 онд Концессоор гүйцэтгэх ажил үйлчилгээний жагсаалтад тусгуулах саналыг 2016 оны 4 сарын 11-ны 1/91 тоотой Төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн.
- Чөлөөт бүсийн хэсэгчилсэн төлөвлөгөө боловсруулах ажлын санхүүжилтийг 2016 оны улсын төсвийн тодотгол, төсвийн хүрээний мэдэгдэлд тусгуулах саналыг Аж үйлдвэрийн яаманд хүргүүлсэн.

1.8 “Чөлөөт бүсэд хөрөнгө оруулах сонирхол бүхий аж ахуйн нэгж байгууллагын төслийг холбогдох журмын дагуу шалгаруулах ажлыг зохион байгуулах” чиглэлээр:

Биелэлт:

- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 01 сарын 04-ний өдрийн 10 дугаар тогтоолоор “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах”, Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам” шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан Замын-Үүд чөлөөт бүсийн Захирагчийн 2016 оны 08 сарын 24 өдрийн А/59 тоот захирамжаар “Төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийн ажиллах заавар”-ыг шинэчлэн баталсан. Тус зааварт газар эзэмших, ашиглах эрхийн төсөл сонгон шалгаруулалтын болон дуудлага худалдааны ялагчтай байгуулах гэрээ, төслийг хүлээн авах, нээх, дүгнэх маягыг баталгаажуулсан.

1.9 “Хил дамнасан чөлөөт бүс байгуулах асуудлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах” чиглэлээр:

Биелэлт:

- Монгол Улсын Ерөнхий сайдын 2015 оны 11 сарын 5-ны өдрийн 216 захирамжаар Монгол Улс БНХАУ хооронд Замын-Үүд Эрээний боомтыг түшиглэн хил дамнасан чөлөөт бүс байгуулах асуудлыг судалж, санал дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Замын-Үүд чөлөөт бүсийн Захирагч орж ажилласан.
- Аж үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 10 сарын 30 -ны өдрийн 266 тоот тушаалаар байгуулагдсан Хил дамнасан чөлөөт бүсийн ТЭЗҮ, Аюулгүй байдал, эрсдлийн үнэлгээ боловсруулах ажлын даалгаврыг боловсруулах ажлын хэсэгт ЗАА-ны холбогдох албан тушаалтнууд оролцон ажилласан. Энэхүү дэд ажлын хэсгээс гадна Аж үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 11 сарын 24-ны өдрийн 281 тоот Захирамжийн дагуу “Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн Ажлын албаны бүрэлдэхүүнтэй дэд ажлын хэсэг байгуулагдсан. Дэд ажлын хэсэг нь “Ажлын хэсгийн удирдамж”-нд тусгагдсан ажил үүргийн дагуу Хил дамнасан чөлөөт бүсийн газрын байрлал, хилийн цэс, хил гааль, хууль эрх зүй, татвар, нийгмийн хэв журам, дэд бүтцийн барилга байгууламж, аюулгүй байдал зэрэг мэдээллийг боловсруулж, санал солилцон, холбогдох шатны удирдлагуудад танилцуулан ажилласан.
- Монгол-Хятадын хил орчмын эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, хил орчмын бүс нутгийн хөгжлийг эрчимжүүлэх талаар хамтран ажиллах тухай Монгол Улсын “Замын-Үүд” чөлөөт бүс, БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орны Эрээн хотын засгийн ордон хооронд харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулсан. Санамж бичигт “Хоёр талын хамтын ажиллагаа нь чөлөөт бүсийн салбарыг хөгжүүлэх, эдийн засгийн орчин, эрдэм шинжилгээ, инновацийн үр өгөөжийг дээшлүүлэх, шинэ техник технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх үйл ажиллагааг дэмжих, боловсон хүчнийг бэлтгэх асуудлыг тууштай хэрэгжүүлэх, чөлөөт бүсийн салбарт мэдлэгт суурилсан хөгжлийн хэв загварыг бий болгоход хамтран ажиллана гэж заасан.
- Хил дамнасан чөлөөт бүс байгуулах ажлын хүрээнд Аж үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 11 сарын 24-ны өдрийн 281 тоот тушаалаар байгуулагдсан “Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн Ажлын албаны бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг БНХАУ-ын Эрээн хотод ажиллав. Уулзалтаар:
 - Замын-Үүд-Эрээний боомтыг түшиглэн хил дамнасан чөлөөт бүс байгуулахаар төлөвлөж буй нутаг дэвсгэрийг хамруулан урьдчилсан ТЭЗҮ боловсруулах ажлын даалгавар,

- Замын-Үүд-Эрээний боомтод хил дамнасан чөлөөт бүс байгуулах асуудлаар “Эрсдлийн үнэлгээ ба менежментийн судалгаа хийх зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар”-ыг тус тус боловсруулж, хоёр тал баталгаажуулсан.
 - Замын-Үүд Эрээний боомт хооронд хил дамнасан чөлөөт бүс байгуулах урьдчилсан ТЭЗҮ-ийг “Сентрополис” ХХК, “Эрсдлийн үнэлгээ ба менежментийн судалгааг “Монгол ус” ТӨҮГ боловсруулан 2016 оны 4 сард судалгааны ажлуудыг хүлээлгэн өгсөн. Хил дамнасан чөлөөт бүс байгуулах урьдчилсан ТЭЗҮ-ийн судалгааны ажлын бүтэц нь Үндсэн тайлан /7 бүлэг, хавсралт, хувилбарын зурагнууд/, Хууль эрх зүйн орчны судалгааны тайлан, 1 боть, “Эрсдэлийн үнэлгээ ба менежментийн судалгааны бүтэц нь Аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээ ба менежмент I, II боть, Эдийн засгийн эрсдэл ба менежмент, Улс төр болон хууль эрх зүйн эрсдлийн үнэлгээ ба менежмент, Байгаль орчны эрсдлийн үнэлгээ ба менежмент гэсэн нийт 5 ботиос бүрдэнэ.
 - БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хотын Захиргаа болон Монгол улсын “Замын-Үүд” Чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны хооронд “Эрээн хот - Замын-Үүдийн хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн бүтээн байгуулалтын ажлыг хамтран түргэтгэх тухай” Санамж бичигт 2016 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр гарын үсэг зурлаа.
 - “Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагч И.Батнасан, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хотын Хөрөнгө оруулалтыг дэмжих газрын орлогч дарга Жөү Жин Ран нар “Эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, хил орчмын бүс нутгийн хөгжлийг эрчимжүүлэхэд хамтран ажиллах” тухай Харилцан ойлголцлын Санамж бичигт 2016 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр гарын үсэг зурсан. Энэхүү санамж бичгийн хүрээнд талууд Замын-Үүд-Эрээн хотын боомтыг түшиглэн хил дамнасан чөлөөт бүс байгуулах асуудлыг судлах, санал дүгнэлт боловсруулах ажилд дэмжлэг үзүүлэх, хил орчмын эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, бүс нутгийн хөгжлийг эрчимжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих талаар хамтран ажиллах, туршлага, мэдлэг солилцохоо мэдэгдлээ.
 - Хятад-Монгол-Оросын эдийн засаг-худалдааны хамтын ажиллагааны БНХАУ-ын Эрээн хот дахь чуулга уулзалтын Хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн тухай Хятад-Монгол-Оросын дугуй ширээний уулзалтын протоколд Захирагч И.Батнасан гарын үсэг зурлаа.
 - Засгийн газрын бүтэц өөрчлөгдөж Замын-Үүд чөлөөт бүсийн ЗАА Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжсэнтэй холбогдуулан Хил дамнасан чөлөөт бүсийн талаарх хууль эрх зүйн зохицуулалт, судалгааны ажлыг үр дүн болон цаашдын хөгжлийн чиг хандлагын талаарх мэдээллийг шат шатны байгууллагуудад танилцуулах шаардлагатай болсон ба одоогийн байдлаар Шадар сайд, түүний ажлын алба, ҮАБЗ-ийн ажлын алба, Тагнуулын байгууллага, Яам тамгын газрын удирдлагуудад, УИХ-ын зарим гишүүдэд танилцуулан санал бодлоо солилцон ажиллаж байна.
- 2. “Чөлөөт бүсэд дэд бүтцийг хөгжүүлэх, бүтээн байгуулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих, чөлөөт бүсэд газар ашиглуулах, эзэмшүүлэхтэй холбогдсон харилцааг зохион байгуулах” зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд:**

2.1 “Замын-Үүд” чөлөөт бүсийн дэд бүтцийн ажлыг хүлээн авах, ашиглалтын үйл ажиллагааг жигдрүүлэх, холбогдох зөвшөөрөл авах ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах” чиглэлээр:

Биелэлт:

- “Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл” болон гүйцэтгэгч байгууллага Чайна Камк Инженеринг компаний удирдлагуудтай хэрэгжүүлж буй ажлын хүрээнд дэд бүтцийн гүйцэтгэлд илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах талаар удаа дараа хурал зөвлөгөөн зохион байгуулж ажилласан.
- “Замын-Үүд” чөлөөт бүс дэх дэд бүтцийн бүтээн байгуулалтын цаашдын ашиглалтыг Захирагчийн Ажлын алба хариуцах талаар “Эрчим хүчний зохицуулах хороо”, “Ус сувгийн удирдах” газруудын холбогдох албан тушаалтнуудтай уулзалт зохион байгуулж, зөвлөмж авч ажилласан. Зөвлөмжийн дагуу тусгай зөвшөөрөл авахад шаардагдах урьдчилсан техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулан, холбогдох бичиг баримтын бүрдлийг ханган ажилласан.

2.2 “Замын-Үүд” чөлөөт бүсийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг техникийн болон улсын комисст хүлээлгэн өгөхтэй холбогдуулан бэлтгэл ажлыг ханган, зохион байгуулан ажиллах” чиглэлээр:

Биелэлт:

- “Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд хийгдэж буй дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг хүлээн авах улсын комисст ажиллах албан хаагчийн нэр /Дэд бүтцийн хөгжил газрын харилцааны хэлтсийн дарга Ц.Ганбат/-ийг Засгийн газрын 2012 оны 151 тогтоолын дагуу Барилга хот байгуулалтын яам, Эрчим хүчний яаманд хүргүүлж ажилласан.
- “Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд хийгдэж буй 4 багц ажлын Дулаан хангамжийн ажилд Эрчим хүчний яамны ажлын хэсэг 2015 оны 09 сард, Цахилгаан хангамжийн ажилд Эрчим хүчний яамны Төрийн Нарийн бичгийн даргын 2015 оны 06 дугаар сарын 24-ний 160 дугаар тушаалаар байгуулагдсан техникийн комисс 2015 оны 07 сард, Усан хангамж, ариутгах татуургын багц ажилд Улсын комисс 2015 оны 08, 11 саруудад тус тус ажиллаж үүрэг даалгавар, зөвлөмж, чиглэл өгч ажилласан. Техникийн болон улсын комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлт, зөрчил дутагдлыг арилгуулах, төслийн ажлыг эрчимжүүлэх, Улсын комиссыг ажиллуулах талаар уулзалт зохион байгуулж, шат шатны байгууллагуудад шаардлага хүргүүлэн ажиллаж байна.
- “Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд хийгдэж буй цахилгаан хангамжийн багц ажилд дүгнэлт, зөвлөмж өгөх үүрэг бүхий “Техникийн комисс 2015 оны 7 сард ажилласан бөгөөд тус комиссоос өгсөн үүрэг даалгаврын дагуу 110 Кв-ын дэд станцын агаарын шугамын хамгаалалтын зурвас зөрчин суурьшсан 46 айл, өрхийг нүүлгэн шилжүүлж, газар чөлөөлөх ажлыг зохион байгуулсан.

2.3 “Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж байгууллагыг бүртгэх, газар эзэмшүүлэх, ашиглуулах ажлыг зохион байгуулах” чиглэлээр:

Биелэлт:

- “Замын-Үүд” чөлөөт бүсэд газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалтаар нийт 154.89 га талбайд 63-н аж ахуйн нэгж байгууллагын 66 битүүмжлэгдсэн төсөл хөтөлбөр ирүүлснээс төсөл нь шалгарсан 32 аж ахуйн нэгжийн 36 төсөлд 81.94 га газрыг олгохоор болсон. Тус 32 аж ахуйн нэгжид холбогдох хууль журмын дагуу эдэлбэр газрын эргэлтийн цэгүүдийг тэмдэгжүүлэх ажлыг Захирагчийн Ажлын Албанаас зохион байгуулан ажилласан. Замын-Үүд чөлөөт бүсийн 2016.06.27-ны өдрийн А/32-с А/47 захирамж, 2016,08,05-ны өдөр А/58 захирамжаар төсөл нь шалгарсан боловч газрын нэг удаагийн төлбөрөө хугацаандаа төлөөгүй 17 аж ахуй нэгжийн төслийг хүчингүй болгосон.
- Чөлөөт бүсийн тухай хууль, Газрын тухай хуулийн дагуу газрын нэг удаагийн төлбөрөө төлсөн 15 аж ахуй нэгж байгаа бөгөөд Шилдээд ХХК-нь газрын нэг удаагийн төлбөрөө төлсөн боловч газар эзэмших эрхийн гэрчилгээ, үйл ажиллагаа явуулах эрхийн бүртгэлийн гэрчилгээ аваагүй байна.
 1. “Тэс петролиум чөлөөт бүс” ХХК
 2. “Сод Монгол Групп чөлөөт бүс” ХХК
 3. “Говийн наран өргөө чөлөөт бүс” ХХК
 4. “Ньютурс Сафарис чөлөөт бүс” ХХК
 5. “Ану Интернешнл чөлөөт бүс” ХХК
 6. “Монголд тавтай морил чөлөөт бүс” ХХК
 7. “Пауэр Фактор чөлөөт бүс” ХХК
 8. “Интер стандарт нефть чөлөөт бүс” ХХК
 9. “Хэв хашмал чөлөөт бүс” ХХК
 10. “Ану Интернешнл чөлөөт бүс” ХХК
 11. “Эморс констракшн чөлөөт бүс”
 12. “Чанг шэн олон улсын ачаа тээврийн чөлөөт бүс” ХХК
 13. “ТР эксим чөлөөт бүс” ХХК
 14. “Пи Пи Жи Чөлөөт бүс ХХК”
 15. “Шилдээд” ХХК

Дээрх 14 аж ахуйн нэгжтэй чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт 15 жилийн хугацаатай газрыг эзэмшүүлэх гэрээ байгуулж, гэрчилгээ олгон, аж ахуйн нэгжийн эзэмшил газрын актыг үйлдэн хүлээлгэн өгч ажилласан.

- “Замын-Үүд” чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулах эрх авсан ААНБ-д газрын тухай хуулийн дагуу байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг хийлгэх талаар шаардлага тавин “Чанг шэн олон улсын ачаа тээврийн чөлөөт бүс” ХХК, “Хэв хашмал чөлөөт бүс” ХХК-ууд хийлгэн чөлөөт бүсийн Захирагчийн Ажлын албанаас БОЯ-руу явуулах тодорхойлолт хүлээгдэж байна.

2.4 “Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, байгууллагын бүтээн байгуулалттай холбогдуулан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах” чиглэлээр:

Биелэлт:

- “Замын-Үүд” чөлөөт бүсэд үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар барилгын ажлаа эхлүүлсэн “Хэв хашмал чөлөөт бүс” ХХК-ийн ажилтан албан

хаагчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалт явуулж, зааварчилгаа өгч ажилласан.

- “Замын-Үүд” чөлөөт бүсэд бүтээн байгуулалтын ажил хийж буй “Чайна Камк Инженеринг”, “Эн Ди Ти Кэй” ХХК-ны удирдлагуудад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн инженер ажиллуулах тухай зөвлөмж өгч, хяналт, тавин ажилласан.
- “Замын-Үүд” чөлөөт бүсийн мэргэжлийн албадын нэгдсэн байранд үүрлээд байсан мэрэгч амьтныг Замын-Үүд суманд байрлах мэрэгч, хортон шавьж устгалын “Жүд Жи Жигдэн” ХХК-тай хамтран 2016 оны 04-05 дугаар саруудад устгал ариутгалын ажил хийсэн.

2.5 “Төслийн гүйцэтгэгч болон төрийн байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог хангах талаар арга хэмжээг авч ажиллах, шаардлагатай шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх” чиглэлээр:

Биелэлт:

- Нэгдүгээр ээлжийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажил удаашралтай, гүйцэтгэл хангалтгүй байгаа тул ажлыг түргэн шуурхай, чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэх тухай “Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн 2016 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн 1/128 дугаар албан тоотыг “Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл”-ийн нэгж, гүйцэтгэгч “Си Эй Эм Си И” ХХК-д хүргүүлсэн. Албан тоотын хувийг БНХАУ-ын ЭСЯ, Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлээ.
- Хил хамгаалах байгууллагатай хийсэн “Хамтран ажиллах журам”-ын дагуу “Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл”, “Чайна Камк Инженеринг”, “Эн Ди Ти Кэй” ХХК, “Хэв хашмал чөлөөт бүс” ХХК зэрэг байгууллагуудад нийт иргэний 323 ш автомашины 81 ш үнэмлэхийг холбогдох дүрэм, журмын дагуу олгож, хяналт тавин ажилласан.
- “Замын-Үүд” чөлөөт бүстэй ажил хэргийн чиглэлээр танилцах хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж байгууллагын зочид төлөөлөгчдийг холбогдох байгууллагад мэдэгдэн, түр хугацаагаар нэвтрүүлэх ажлыг тухай бүрт зохион байгуулан ажилласан.
- Чөлөөт бүсэд бүтээн байгуулалтын ажил хийж буй аж ахуйн нэгж байгууллагыг чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт Хилийн 0108 дугаар ангийн Захирагч, “Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагч нарын 2016 оны 04 сарын 04-ний 02/А13 тоот хамтарсан захирамжийн 1 дүгээр хавсралт “Замын-Үүд” чөлөөт бүсийн харуул хамгаалалтын үйл ажиллагаанд 2016 онд мөрдөх журам”-ын 3-т заасны дагуу нэвтрүүлэх, үнэмлэхжүүлэх ажлыг Хил хамгаалах байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн. “Хамтран ажиллах журам”-д чөлөөт бүсэд нэвтрэх үнэмлэхийг 3 төрөл байхаар тусгаж батлуулан ажилласан.
 - Чөлөөт бүсэд нэвтрэх /Иргэн/
 - Чөлөөт бүсэд нэвтрэх /Тээврийн хэрэгсэл/
 - Чөлөөт бүсэд нэвтрэх /Түр үнэмлэх/

3. “Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх” зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд:

3.1 “Кластер, чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэх эрх зүйн таатай орчин бий болгох” арга хэмжээний хүрээнд:

Биелэлт:

- Чөлөөт бүсэд бизнес эрхлэх аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг бодлогоор дэмжиж хөрөнгө оруулалтын гэрээний загвар, гэрээ байгуулах зааварт Чөлөөт бүсийн тухай хуулийн 16 дугаар зүйлд тусгагдсан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх асуудлыг тодорхой тусгаж, хуулиар нарийвчлан зохицуулагдаагүй хөнгөлөлт, чөлөөлөлтийн эхлэх, дуусах огноо, календарьчилсан графикийг аж ахуйн нэгж байгууллагын бизнесийн үйл ажиллагаанд дарамт болохгүйгээр, харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэхээр холбогдох зохицуулалтыг тусгаж өгсөн.

3.2 “Чөлөөт бүс дэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдсон дүрэм, журмыг холбогдох хууль тогтоомжинд нийцүүлэн боловсруулж, батлуулах” чиглэлээр:

Биелэлт:

- Чөлөөт бүсийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой дүрэм, журмыг боловсруулан баталж, мөрдлөг болгон ажилласан. Үүнд:
 - Чөлөөт бүсэд бараа материал оруулах горим /ГЕГ-ын 2016 оны 2 сарын 24-ны А/43 тоот тушаалаар батлагдсан/
 - Хил хамгаалах ерөнхий газартай хамтран ажиллах гэрээ /2016 оны 1 сарын 13-ны 03/01 тоот/
 - Хилийн 0108 дугаар ангитай хамтран ажиллах журам /2016 оны 4 сарын 04-ны 02/А/13
- Чөлөөт бүсэд байцаагч томилох талаар Гааль Татварын Ерөнхий газраас 2016 оны 05 сарын 09-ны өдрийн 01/499 албан тоотор “Замын-Үүд” чөлөөт бүсэд гаалийн улсын ахлах байцаагч 1, улсын байцаагч 2-ыг томилуулан ажиллуулж байна.

3.3 “Холбогдох яам, агентлаг, байгууллага болон төрийн өндөр албан тушаалтанд шаардлагатай үйлчилгээг үзүүлэх” чиглэлээр:

Биелэлт:

Зорилтын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Үүнд:

- Аж үйлдвэрийн сайд, Төрийн нарийн бичгийн дарга болон нэгжийн дарга нарыг салбарын бодлого, хууль эрх зүйн хэрэгжилт, дэд бүтцийн төслийн ажлын явц, төсөл сонгон шалгаруулалтын үр дүнгийн талаархи мэдээллээр бүрэн хангаж ажилласан.

- Төрийн албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан, албан хаагчдын хаягийн мэдээлэл, түр орлон гүйцэтгэх журмын дагуу ажиллаж байгаа албан хаагчдын мэдээлэл, судалгааг цаг тухайд нь боловсруулан Аж үйлдвэрийн яамны Төрийн захиргаа, удирдлагын газарт хүргүүлэв.
- Захирагчийн ажлын төлөвлөгөөг гаргах, бусад баримт бичиг боловсруулах, цаг үеийн чанартай уулзалт, хурал зөвлөгөөний бэлтгэл ажлыг зохион байгуулах, бүсийн захирагчид танилцуулах, гарын үсэг зуруулах материалыг шалгаж иж бүрдлийг ханган ажилласан.
- Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл судалгаа, хууль тогтоомж, цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан "Засгийн газрын 100 хоног" арга хэмжээнд хийсэн ажлын тайланг хүргүүлэн ажиллав.

3.4 “Төсвийн шууд захирагчийн Үр дүнгийн гэрээний төсөл боловсруулах, батлуулах ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах” чиглэлээр:

Биелэлт:

- Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээг боловсруулан, Аж үйлдвэрийн сайдаар Замын-Үүд чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан, Үр дүнгийн гэрээний биелэлтэд хяналт тавьж, зохион байгуулалтаар ханган ажиллаж байна.

3.5 “Замын-Үүд” чөлөөт бүсийн ажилтан алба хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг ханган ажиллах” чиглэлээр:

Биелэлт:

- Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр доорх ажлыг зохион байгуулав.

Үүнд:

- Захирагчийн 2016.01.26-ний өдрийн А/05 тоот захирамжаар "Авлигаас урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, мэргэшил мэдлэгийг дээшлүүлэх сургалтын төлөвлөгөө" боловсруулан батлуулсан.
- Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөөгүй ажилтнуудыг тангараг өргүүлж, төрийн жинхэнэ албан хаагч болгох ажлыг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлтэй хамтран зохион байгуулж 4 албан хаагч тангараг өргөсөн.
- Байгууллагын "Хөдөлмөрийн дотоод журам" болон бусад холбогдох журмын дагуу 1 албан хаагчид буцалтгүй тусламж, 6 албан хаагчид урамшуулал, 4 ажилтанд цалинтай чөлөө олгосон.
- Албан хаагчдын гаргасан өргөдөл, хүсэлтийг хяналт шалгалт хийж, тулгамдсан асуудлуудыг тухай бүр хууль тогтоомжид нийцүүлэн хариу өгч, Захирагчийн захирамжаар баталгаажуулан шийдвэрлэсэн.

- “Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль”-ийн дагуу ажиллаж байсан ахмад настанд хүндэтгэл үзүүлсэн.
- Ажилтны ажилдаа ирэх, буцах нийтийн тээврийн унааны зардал, хоолны үнийн зохих хувийг холбогдох хууль, журмын дагуу сар бүр олгож байна.

3.6 “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг сайжруулах” чиглэлээр:

Биелэлт:

- Байгууллагын албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагаанд шаардлагатай холбогдох дүрэм, журмын дагуу хэрэгжилтийг ханган ажилласан.

Үүнд:

- Байгууллагын дотоод журам, албан хэрэг хөтлөлтийн журам зааварт заасны дагуу байгууллагын ирсэн, явсан албан бичгийн бүртгэл, хяналтын хуудсын шийдвэрлэлтийн байдалд хяналт тавьж ажилласан.
- Төрийн болон төрийн бус аж ахуйн нэгжүүдээс ирсэн 229ш албан бичгийг бүртгэж, албажуулан холбогдох хэлтэс, ажилтнуудад хүлээлгэн өгч шийдвэрлэлтийн явц, хугацаанд хяналт тавин ажилласан. Нийт 229 албан бичиг ирснээс 73 нь төрийн байгууллагаас, 154ш нь хувийн байгууллагаас ирсэн. Дээд газруудаас ирсэн бичгийн шийдвэрлэлт 100 хувь байна.
- Захирагчийн баталсан дүрэм журам, А захирамж 71, Б захирамж 50-ийг албажуулан холбогдох хэлтэс, ажилтанд танилцуулан ажилласан.
- Захирагчийн Ажлын албаны хэлтсүүдээс боловсруулсан 240ш албан бичгийг албажуулж холбогдох газруудад илгээсэн.
- Архивын тухай хууль, болон бусад холбогдох хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, холбогдох хууль журмын дагуу хэлтсүүдээс санал аван ТЕГ-аас зөвшөөрөл олгосны дагуу нууцын ажилтанг томилон, архиваас холбогдох нууцын материалуудыг ялган бүртгэл хөтөлж, актаар хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулсан.
- Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологийг нэвтрүүлэх ажлыг судлан хэлтсийн мэдээллийн цагаар “Able soft” компаниас мэргэжилтэн урьж ажилтан хаагчдад албан хэрэг хөтлөлтийн программын талаар танилцуулав.
- 2015 оны 12 сарын 17-ны өдрийн А/78 тоот захирамжаар архивт баримт бичиг хүлээлгэн өгөх хуваарийг батлуулан, хэлтсүүдээс нийт 101 ширхэг хавтаст хэрэг, диск архивлан ажилласан.

3.7 “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг зохих журмын дагуу хугацаанд нь гаргуулж, холбогдох тайлан мэдээг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх” чиглэлээр:

Биелэлт:

- Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Албан тушаалтны хувийн ашиг сонирхол, хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, хяналт тавих журам"-ын 3 дугаар зүйлийн 3.3-т заасны дагуу холбогдох тайлан мэдээг хугацаанд нь үнэн бодит гаргаж хүргүүлэх арга хэмжээг авч ажиллаж байна. Үүнд:
 - Шинээр томилогдох ажилчдын хөрөнгө орлогын урьдчилсан мэдүүлгийг тухай бүр авч, баримт материалыг нэгтгэн Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн, хариуг авч ажилласан.
 - Шинээр томилогдсон болон албан тушаалд шилжүүлэн томилсон 13 албан хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлгийг цахимаар бөглүүлж баталгаажуулан, цаасаар хэвлэн авч хадгаламжийн нэгжид хадгалсан.
 - Авлигатай тэмцэх газар болон Засгийн газрын хэрэг эрхлэх газрын хөрөнгө орлогын мэдүүлэг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтнаас өгсөн зөвлөмжийг үйл ажиллагаандаа тусгаж, заавар зөвлөгөө аван ажиллаж байна.
- Нийт ажилтан албан хаагчдыг гарын авлага материалаар хангах, хууль сурталчлах ажлуудыг зохион байгуулж, АТГ-ын соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх хэлтэстэй хамтран сургалт зохион байгуулав.
- Чөлөөт бүсэд мөрдөгдөх дүрэм, журам, шийдвэрийг нийтэд ил тод мэдээлэх. Чөлөөт бүсэд мөрдөгдөх дүрэм, журам, шийдвэрүүдийг жагсаалтын хамт байгууллагын цахим хуудсаар нийтэд ил тод мэдээлсэн.

3.8 "Ажлын албаны дотоод дэг журмыг сахиулах, цаг ашиглалт, ажлын уялдаа холбоог сайжруулах арга хэмжээг зохион байгуулах" чиглэлээр:

Биелэлт:

- Нийт ажилтан албан хаагчдын ажлын цаг ашиглалт, ажлын уялдаа холбоог сайжруулах талаар тухай бүр арга хэмжээ авч, цагийн бүртгэлийн программаар ажлын цагийн тооцоог сар бүр гарган холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.
- Байгууллагын "Ёс зүйн хороо"-ны 2016 оны 02 дугаар сарын 04-ны өдрийн хуралдаанаас байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах, хөдөлмөрийн удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах, Төрийн албаны болон Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан стандартыг хууль тогтоомжид нийцүүлэхэд шаардлагатай асуудлаар зөвлөмж гаргаж удирдлагуудад танилцуулсан.
- Албан хаагчдын ажлын уялдаа холбоог хангах зорилгоор "Ажлын байрны тодорхойлолт"-д тодотгол хийж ажиллав.

4. “Гадаад харилцаа, хамтын ажллагааг хөгжүүлэх, зөвлөгөө, мэдээлэл өгөх, мэдээллийн технологийн найдвартай байдлыг хангах” зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд:

4.1 “Чөлөөт бүсийг хөгжүүлэх чиглэлээр гадаад орнууд, олон улсын байгууллагатай хамтын ажиллагааг эрчимжүүлэх” чиглэлээр:

Биелэлт:

Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхээр дараах арга хэмжээг зохион байгуулж ажилласан. Үүнд:

- “Замын-Үүд” чөлөөт бүсийн бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбогдуулан Монгол улсын “Замын-Үүд” чөлөөт бүс, БНХАУ-ын Эрээн хотын Засгийн ордон хооронд хамтран ажиллах тухай 2015 оны 1 сард байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийг шинэчлэх төслийг боловсруулан хоёр талын саналын үндсэн дээр гэрээг албажууллаа.
- “Замын-Үүд” чөлөөт бүсийн бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбогдуулан Монгол улсын “Замын-Үүд” чөлөөт бүс, БНХАУ-ын Эрээн хотын Засгийн ордон хооронд хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичиг, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хотын Захиргаа болон Монгол улсын “Замын-Үүд” Чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны хооронд “Эрээн хот - Замын-Үүдийн хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн бүтээн байгуулалтын ажлыг хамтран түргэтгэх тухай” санамж бичиг, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хотын Хөрөнгө оруулалтыг дэмжих газар, Монгол улсын “Замын-Үүд” Чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны хооронд “Эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, хил орчмын бүс нутгийн хөгжлийг эрчимжүүлэхэд хамтран ажиллах” тухай Харилцан ойлголцлын Санамж бичгийн төслийг боловсруулж, холбогдох албан тушаалтнуудаас санал авч албажуулах ажлыг зохион байгуулав.
- Чөлөөт бүсийн үйл ажиллагаатай чиглэл нэг, цаашид хамтран ажиллах гадаадын байгууллага, олон улсын чөлөөт бүсүүдийн судалгааг хийсэн. Үүнд: Америкийн нэгдсэн улсын бүх төрлийн 260 гаруй чөлөөт бүсийн нэгдсэн мэдээллийн сантай сайтнаас судалгаа хийн ажиллаж байна. Одоогийн байдлаар The National Association of Foreign Trade Zones of USA and Miami Free Zone гэсэн чөлөөт бүсрүү имэйл илгээж, хамтран ажиллах хүсэлтээ илэрхийлээд байна.
- Бүгд Найрамдах Турк улсын худалдааны чөлөөт бүстэй харилцан хамтын ажиллагаатай байж мэдээлэл солилцох, туршлага судлах саналыг хүргүүлж, “Замын-Үүд” чөлөөт бүсийн танилцуулга материалыг имэйл хаягаар хүргүүллээ.
- Аж үйлдвэрийн яам, Алтанбулаг чөлөөт бүсийн ЗАА-аас “Алтанбулаг экспо-2016” олон улсын форум, үзэсгэлэн худалдааг 05 дугаар сарын 20-22-ны өдрүүдэд Сэлэнгэ аймгийн “Алтанбулаг” чөлөөт бүсэд зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээний үеэр Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын “Эдийн засгийн коридор байгуулах”, гурван улсын хамтын ажиллагаа, хил дамнасан тээврийг хөнгөвчлөх, дэд бүтцийг хөгжүүлэх, худалдааны эргэлтийн хэмжээг нэмэгдүүлэх, бараа, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг хангах, улмаар гурван улс хоорондын санхүү, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааг хөхүүлэн дэмжих, чөлөөт бүсийн үйл ажиллагааг

идэвхжүүлэх” уулзалтууд зохион байгуулагдлаа. Уг арга хэмжээнд Захирагчийн 2016 оны А/24 тоот захирамжаар томилогдсон 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг оролцож “Замын-Үүд” чөлөөт бүсийн дэд бүтэц, хууль эрхзүй, татварын хөнгөлөлт, газар зохион байгуулалтын талаар сурталчилгаа хийж, “Дэлхийн чөлөөт бүсийн хөгжлийн чиг хандлага, Монголын чөлөөт бүсийн өнөөгийн байдал” салбар хуралдаанд оролцлоо.

4.2 “Салбарын хүний нөөц бэлтгэх, сургах, мэргэшүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ” чиглэлээр:

Биелэлт:

- Байгууллагын хүний нөөцийг сургах, мэдлэг чадварыг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд “Сургалт, мэдээллийн цаг”-ийн хуваарийг Захирагчийн 2016 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/02 дугаар захирамжаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан. “Сургалт, мэдээллийн цагийн хуваарь”-ийн дагуу 2016 онд нийт 14 удаа мэдээлэл хийгдсэн байна.
- Замын-Үүд чөлөөт бүсийн ЗАА-ны албан хаагчдын хамрагдсан гадаад дотоодын сургалт:
 - ГХЯ-наас зохион байгуулсан “Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах журам”, гадаад бодлого, үйл ажиллагаа, дэг жаяг, нэгдсэн зохицуулалтын талаарх зөвлөмж, сургалт,
 - Монголын Програм Хангамж Үйлдвэрлэгчдийн Холбооноос санаачлан Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газартай хамтран зохион байгуулсан төрийн албан хаагчдад зориулж мэдээллийн технологийн шилдэг шийдлийг ашиглаж цахим засгийг хөгжүүлэх талаар мэдлэг, мэдээлэл өгөх зорилготой чуулга уулзалт
 - Хууль зүйн яам, Германы хамтын нийгэмлэгээс хамтран зохион байгуулсан “Хууль тогтоомжийн тухай хуульд заасан аргачлалуудыг хэрэглэх дадлага олгох сургалт”
 - МУИС-иас зохион байгуулсан “Гурван улсын эдийн засгийн коридорыг Монгол улсын гео-эдийн засгийн сонирхолтой уялдуулах нь” сэдэвт олон талт судалгааны аялал
 - БНХАУ-ын Шанхай “Чөлөөт худалдааны бүсийн стратеги семинар Монгол улс ” сэдэвт сургалт

2016 оны байдлаар гадаад дотоодын сургалт, бусад арга хэмжээнд давхардсан тоогоор нийт 23 албан хаагч хамрагдсан байна.

- Гадаад хэргийн яамны бодлого төлөвлөлтийн газрын захирал Ш.Одонбаатарт байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагаатай холбогдох гадаад, дотоодын сургалтанд оролцуулах хүсэлт бүхий албан захидлыг хүргүүлээд байна.
- “Эрээн-Замын-Үүдийн хамтын ажиллагааны санамж бичиг”-ийн хүрээнд БНХАУ-ын их дээд сургуульд инженер, эдийн засаг, мэдээлэл технологи, хүний нөөцийн

хөгжил, олон нийттэй харилцах чиглэлээр ажилтан бэлтгэх, сургалтанд албан хаагчдыг хамруулах тухай хүсэлтийг ӨМӨЗО-ны Эрээн хотын дэд дарга н.Цогзолд илгээсэн бөгөөд уг ажил хэлэлцээрийн түвшинд явагдаж байна.

4.3 “Чөлөөт бүсийн талаар гадаад болон дотоодын аж ахуйн нэгжид танилцуулах, сурталчлах ажлыг зохион байгуулах” чиглэлээр:

Биелэлт:

- “Хятад, Монгол, Орос гурван улсын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны Эрээн хот чуулга уулзалт-2016”, энэ үеэр зохион байгуулагдсан “Хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн тухай дугуй ширээний уулзалт”-ын үеэр БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хотын Захиргаа болон БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хотын Хөрөнгө оруулалтыг дэмжих газрын албаны хүмүүс, БНХАУ-ын ӨМӨЗО-оос Замын-Үүдэд суугаа ерөнхий консул Цай Вэньруй, дэд консул Хан болон Эрээн хотын Засгийн ордны хүсэлтээр холбогдох албаны хүмүүст, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Фан Данг Дыөнг зэрэг албаны хүмүүст чөлөөт бүсийн үйл ажиллагаа, салбарын бодлого, хууль, эрх зүйн орчин, татварын таатай нөхцөл, зах зээлийн давуу байдлын талаар танилцуулга хийгдсэн.
- БНХАУ-ын Эрээн хотын хүсэлтээр татварын хөнгөлөлт чөлөөлөлт, газрын харилцаа, гааль хяналтын зохицуулалт, банк санхүү, даатгал, аж ахуйн нэгжийн бүртгэл, холбогдох хуулиудын талаарх мэдээлэл, чөлөөт бүсэд газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалтын ажлын явцын талаар мэдээлэл өгч ажиллав.
- Дорноговь аймгийн засаг даргын тамгын газрын ОНХА-Иргэдийн мэдээллийн төвийн хүсэлтээр чөлөөт бүсийн бүтээн байгуулалтын талаарх мэдээлэл, “Алтанбулаг экспо” ОУ-ын арга хэмжээний үеэр байгууллагын танилцуулга материалыг 100 гаруй зочид, хөрөнгө оруулагчдад хүргэж, чөлөөт бүсийн бүтээн байгуулалт, газар зохион байгуулалт, давуу талыг арга хэмжээнд оролцогчдод танилцуулга хийсэн.
- Иргэд, аж ахуй нэгжийн төлөөлөл Глобал линк Монголиа" ХХК, "Орос-Монгол" ХХК, "Цэвэр Монгол" ХХК, "TGI" ХХК, Өгөөмөр ОУ-ын худалдааны төв, ТЭСО компани, Бату-Цэ ХХК болон судалгаа хийж буй МУИС-ын оюутнуудыг чөлөөт бүсийн танилцуулга хууль эрхзүйн орчны мэдээллээр хангаж ажиллав. МУИС-иас зохион байгуулсан “Гурван улсын эдийн засгийн коридорыг Монгол улсын гео-эдийн засгийн сонирхолтой уялдуулах нь” сэдэвт олон талт судалгааны аялалд оролцогч нийт 38 төлөөлөгчдөд чөлөөт бүсээ танилцуулж, танилцуулах материал, холбогдох мэдээллийг өгч ажилласан.
- “Замын-Үүд” чөлөөт бүсийн дэд бүтцийн бүтээн байгуулалт, хууль эрх зүйн орчин, татварын хөнгөлөлттэй нөхцөл, давуу талын мэдээллийг багтаасан танилцуулга, чөлөөт бүсийн тухай хүүлийг Монгол Хятад, Орос, Англи хэл дээр шинэчлэн бэлтгэж олны хүртээл болгосон.

4.4 “Хэвлэл мэдээллийн байгууллага, иргэд, аж ахуйн нэгжийг шаардлагатай мэдээллээр хангаж ажиллах” чиглэлээр:

Биелэлт:

- ХОХБХ-ийн мэргэжилтэн Д.Ганбат 2016 оны 1 дүгээр сарын 11-ны өдөр “ТҮ5” телевизийн ярилцлаганд оролцож “Замын-Үүдийн чөлөөт бүсийн дэд бүтцийн ажил дуусаж бүтээн байгуулалт эхлэв” гэсэн мэдээллийг өгсөн. Мэдээний бичлэгийг байгууллагын цахим хуудсанд байршуулж ажиллав.
- BloombergTV Mongolia телевиз болон сайтад “Аж ахуй нэгжүүд чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх бүртгэлийн гэрчилгээгээ авлаа”, “TV9” телевизээр “Замын-Үүд” чөлөөт бүс Хил хамгаалах ерөнхий газартай хамтран ажиллах гэрээ байгууллаа” гэсэн гарчигтай мэдээллүүд цацагдсан.
- Монголын Худалдаа Аж үйлдвэрийн танхимын “Бизнес ба хөгжил” сэтгүүлийн А/4 хэмжээний 3 нүүрээр, “Бизнес таймс” сонинд А/3 хэмжээний 2/1-ын хэмжээнд “Замын-Үүд” чөлөөт бүсийн дэд бүтцийн бүтээн байгуулалт, хууль эрх зүйн орчин, аж ахуй нэгжид үзүүлэх хөнгөлөлт чөлөөлөлт, бүсэд газар ашиглуулах, эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтын талаарх материалыг бэлтгэн өгч, нийтлүүлсэн бөгөөд “Алтанбулаг экспо-2016” арга хэмжээнд оролцогч гадаад дотоодын аж ахуйн нэгж байгууллага, хөрөнгө оруулагчдад тараагдсан болно.

4.5 “Чөлөөт бүсийн мэдээллийн технологийн найдвартай байдлыг хангах, мэдээллийн сүлжээ, санг хөгжүүлэх” чиглэлээр:

Биелэлт:

- “Замын-Үүд” чөлөөт бүсийн үйл ажиллагааны талаар аж ахуйн нэгж байгууллага, олон нийтийг мэдээ мэдээллээр хангах, мөн төрийн байгууллагын вэб сайтад тавигдах шаардлагыг MNS 6285:2011 стандартад нийцүүлэн байгууллагын веб хуудасны загварыг шинэчилж, www.zfz.gov.mn болгон өөрчлөх ажлыг зохион байгуулсан ба иргэд, аж ахуй нэгж, хөрөнгө оруулагчдад нээлттэй, хүртээмжтэй, үнэн, бодит мэдээ, мэдээлэл, үйлчилгээг хүссэн үед дурын цэгээс гар утас, компьютерээр авах, татаж авах хэлбэрээр байршуулсан. МТ-ийн аюулгүй байдлыг хангах үүднээс албан хаагчдын компьютерүүдийг нууц үгтэй болгож IP, MAC хаягуудыг бүртгэж ямар нэгэн сүлжээний халдлагаас хамгаалах арга хэмжээ авч ажиллаж байна.
- Захирагчийн Ажлын албанаас гаргасан дүрэм, журам, цаг үеийн чанартай 45 мэдээ мэдээллийг байгууллагын цахим хуудсанд тухай бүр байршуулж ажиллав.
- Чөлөөт бүсийн талаарх зөвлөгөө, мэдээллээр хангах зорилтын хүрээнд байгууллагын цахим хуудасны хятад, англи, орос хэл дээрх блогийг баяжуулан ажилласнаар 2016 оны байдлаар блогт 2853, цахим хуудсанд 375723 хэрэглэгч хандсан нь өмнөх оныхоос 326651 хэрэглэгчээр илүү байна.
- Замын-Үүд” чөлөөт бүсийн ажилтан албан хаагчид бусад байгууллагуудтай цахимаар мэдээлэл солилцох, холбоо тогтоох боломжийг бүрдүүлэх зорилгоор нийт албан хаагчдыг албаны эмайл хаягтай болгох ажлыг зохион байгууллаа.

5. “Чөлөөт бүсийн бүртгэл, санхүү, төсвийн удирдлагыг хангах” зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд:

5.1 “Санхүүгийн удирдлага, аж ахуйн үйлчилгээгээр хангах арга хэмжээг хэрэгжүүлэх” чиглэлээр:

Биелэлт:

- Байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах, төрийн мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль тогтоомж, “Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн захирамж, шийдвэрүүдийг байгууллагын цахим хуудсанд байршуулж, төсвийн хөрөнгийн зарцуулалтыг нийтэд мэдээллэж байна.
- Захирагчийн Ажлын албаны нэгжүүдийн хэрэгцээт тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, засвар болон бараа материалын зардлуудын төлөвлөлтийг гаргуулж, тэдгээрийг үндэслэн төсвийн хязгаарыг нэмэгдүүлж төлөвлөх тооцоог гаргаж, төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн ажиллав. Түүнчлэн цаг үеийн холбогдолтой дараах асуудлуудыг шийдвэрлэсэн. Үүнд:
 - 2016 оны батлагдсан төсвийн санхүүжилтийн хуваарьт багтаан албан хаагчдын сар бүрийн цалинг тооцон олгож, нийгмийн даатгал, хүн амын орлогын албан татвар, шуудан холбоо, цэвэр бохир ус, байрны түрээс, цахилгаан дулааны төлбөр тооцоог сар бүр холбогдох байгууллагуудын нэхэмжлэхийг үндэслэн тооцоо хийсэн.-“Замын-Үүд” чөлөөт бүсэд байрлах Мэргэжлийн албадын нэгдсэн байрны тогтмол зардлыг гэрээ, гүйцэтгэлийн дагуу сар бүр хийж ажилласан.
 - “Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн Ажлын албаны сайт болох www.zfz.gov.mn сайтын “Шилэн данс” цэсэнд төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, Шилэн дансны SHILENDANS.GOV.MN сайтад 2016 оны эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэлийн орлого, зарлагын мэдээг баталгаажуулж, 2016 оны хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний мэдээлэл, 2016 оны байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбар, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт зэрэг мэдээллийг хуулийн хугацаанд нь байршууллаа.

5.2 “Замын-Үүд” чөлөөт бүсийн төсөв төсөөллийг боловсруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх” чиглэлээр:

Биелэлт:

- “Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн Ажлын албаны 2016 оны төсвийн тодотголд санал өгч, 2017 оны төсвийн хязгаарын саналаа Аж үйлдвэрийн яаманд албажуулан хүргүүлсэн.
- 2017 оны төсвийн төслийг Аж үйлдвэрийн яамны санхүү, эдийн засгийн хэлтэст хүргүүлсэн.

- 2016 оны төсвийн тодотгол, 2017 оны төсвийн хүрээний мэдэгдлээ Шадар сайдын ажлын албанд хүргүүлэн ажиллалаа. /2016 оны 3АА батлагдсан төсөв 529 сая төгрөг /
- 2017 оны төсвийн төсөл 2018-2019 оны төсвийн төсөөллийг Сангийн яаманд хүргүүлсэн.

5.3 “Холбогдох журмын дагуу эд хөрөнгө бараа материал худалдан авч тайлагнах” чиглэлээр:

Биелэлт:

- 2016 онд Захирагчийн Ажлын албаны албан хэрэгцээнд шаардлагатай “Багаж техник, хэрэгсэл” худалдан авах зориулалт бүхий батлагдсан төсвийн хуваарийн саналыг 2016 оны 03 сарын 10-ны өдрийн 1/44 тоотгоор Төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсний дагуу Acer , HP , Del нэрийн 16 ширхэг компьютерыг 18,479,320 төгрөгөөр, HP-LJ1102 5 ширхэг принтер 1,099,500 төгрөгөөр, HP-SJ 200 сканнер 1 ширхэг 169,900 төгрөг, **нийт 19,748,720 төгрөгийн тоног төхөөрөмж**, байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд шаардагдах бичиг хэргийн материал, принтерийн хор болон бусад шаардлагатай бараа материалыг зохих журмын дагуу худалдан авч, байгууллагын үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй явуулах нөхцөл боломжийг хангаж ажиллав.

5.4 “Байгууллагын эд хөрөнгийн ашиглалтыг сайжруулах” чиглэлээр:

Биелэлт:

- Төрийн өмчийн хорооны 2015 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 3/2930 тоот албан тоотгоор ирсэн 752,452,60 , / Долоон зуун тавин хоёр мянга дөрвөн зуун тавин төгрөг жаран мөнгө/ төгрөгийн үндсэн хөрөнгийг актлах зөвшөөрөл, Байгууллагын “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийн 2015 оны 12-р сарын 22-ны өдрийн хуралдаанаас гаргасан, 14 нэр төрлийн 584,454 /Таван зуун наян дөрвөн мянга дөрвөн зуун тавин дөрөв/ төгрөгийн бараа материалыг актлах шийдвэрийг тус тус үндэслэн бараа материал, үндсэн хөрөнгийг актлах ажлыг зохион байгууллаа.
- “Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны 2015 оны жилийн эцсийн үндсэн хөрөнгийн хөдөлгөөний тайлангийн мэдээллийг Сангийн яамны төрийн өмчийн удирдлага, бүртгэл, тооллого, хяналтын газарт хүргүүлэв.
- 2015 оны жилийн эцсийн байдлаар 3,034,868,608.07 төгрөгийн үлдэх өртөгтэй хөрөнгийг сангийн яамны программд шивж, баталгаажуулсан.
- Сангийн яамны төрийн өмчийн удирдлага, бүртгэл, тооллого, хяналтын газарт “Сонота-4” автомашин актлах болон үндсэн хөрөнгө худалдан авах талаар холбогдох албан тоотуудыг явуулж, тус яамнаас өгсөн чиглэлийн дагуу дараагийн шатны дуудлага худалдааг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.
- Монгол Улсын сангийн сайдын 2016 оны 04 сарын 06 ны өдрийн “Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах” тухай 126 дугаар тушаалын хэрэгжилтийг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг 2016 оны А/20

тоот захирамжаар томилж, Дорноговь аймгийн Замын-Үүд дэх чөлөөт бүсэд байрлах Мэргэжлийн албадын нэгдсэн байр, Захирагчийн Ажлын албаны албан хэрэгцээнд ашиглаж буй эд хөрөнгийн тооллогыг удирдамжийн дагуу хийж, гүйцэтгэлийн тайланг Төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн, ажилтан, албан хаагчдын хариуцдаг эд хөрөнгийн бүртгэлийн картыг шинэчлэв.

5.5 “Аудитын хяналт шалгалтанд зохих журмын дагуу бэлтгэн, зөрчил дутагдалгүй ажиллах” чиглэлээр:

Биелэлт:

- “Өлзийт Экаунт Аудит” ХХК-ийн ЗАА-д хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг Аж үйлдвэрийн яамны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын санхүү эдийн засгийн хэлтэст хүргүүлсэн. Аудитын шалгалтаар алдаа зөрчилгүй ажилласан.
- Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүнг шилэн дансны мэдээлэлд оруулав.
- Аж үйлдвэрийн яаманд төрийн аудитын 1-3 дугаар улирлын шилэн данс болон холбогдох мэдээлэл боловсруулж харилцах хүмүүсийн талаархи судалгааг өгөгдсөн маягтын дагуу онлайнаар хүргүүлэв.

5.6 “Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийг бүртгэх, холбогдох хууль, журмын дагуу төлбөр, хураамжийг төсөвт төвлөрүүлэх ажлыг хэрэгжүүлэх” чиглэлээр:

Биелэлт:

Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх төсөл сонгон шалгаруулалтанд шалгарсан аж ахуйн нэгжүүдийг холбогдох хууль, журмын дагуу бүртгүүлэх, холбогдох төлбөр, хураамжийн талаарх зөвөлгөө, мэдээллээр хангаж ажиллав.

- Тайлангийн жилд аж ахуй нэгжийн газрын нэг удаагийн төлбөр 183 150 000 төгрөг, бүртгэлийн гэрчилгээний үнэ болон бусад хураамжаас 629 500 төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. 2016 онд 11 аж ахуйн нэгжид чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх бүртгэлийн гэрчилгээ олгосон.
- 2016 оны байдлаар Төсөл сонгон шалгаруулалтаар шалгарсан 15 аж ахуйн нэгжид 23,6 га газрыг олгож, Улсын төсөвт газрын нэг удаагийн төлбөр болон бусад хураамжаас бүрдсэн 318,5 сая төгрөг төвлөрүүлээд байна

Төрийн захиргааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлэх асуудал:

1. “Замын-Үүд” чөлөөт бүсэд газар олголтын ажил эхэлсэнтэй холбогдуулан “Газрын тухай хуулийн” 35 дугаар зүйлийн 35.1.2, 58 дугаар зүйлийн 58.7-д заасны дагуу “Замын-Үүд” чөлөөт бүсийн 900 га тайлбайд “Газрын төлөв байдал чанарын улсын хянан баталгаа” хийлгэх хөрөнгө, санхүүгийн асуудлыг шийдвэрлүүлэх,
2. “Замын-Үүд” чөлөөт бүсийн газар эзэмшил, ашиглалтанд хяналт тавих, газар зохион байгуулалтыг зөв зохистой явуулахад нэн шаардлагатай “Газар хэмжилтийн багаж, тоног төхөөрөмж”-ийн асуудлыг шийдвэрлүүлэх,

3. “Замын-Үүд” чөлөөт бүсийн мастер төлөвлөгөөнд тулгуурлан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийлгэх хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх,
4. Чөлөөт бүсийн 2-р ээлжийн дэд бүтцийн ажлыг Энэтхэг, БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт хамруулах,
5. Чөлөөт бүсийн хилийн болон гүнийн гарцанд иргэд аж ахуйн нэгжид үйлчлэх шалган нэвтрүүлэхийн барилга байгууламж, техник, тоног төхөөрөмж, нэгдсэн сүлжээний төсвийг шийдвэрлүүлэх,
6. Чөлөөт бүсийн 2-р ээлжийн дэд бүтцийн ажлыг концессын гэрээгээр хийж хэрэгжүүлэх удирдлага арга зүйгээр хангах,
7. Бусад орны чөлөөт бүстэй танилцах, туршлага судлах, сургалтанд хамруулах,
8. Чөлөөт бүсийн үйл ажиллагааг олон улсад сурталчлан таниулах, иргэд байгууллагыг мэдээллээр хангах, шаардлагатай программ худалдан авахад шаардагдах хэвлэл мэдээллийн зардал, гадаад томилолтын зардлыг тус тус шийдвэрлүүлэх саналыг хүргүүлж байна.

ЗАМЫН-ҮҮД” ЧӨЛӨӨТ БҮСИЙН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА
2016-12-21